

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Даланзадгадын дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2023/15/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Даланзадгад хот
2023 он

Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК
Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.15 № 243

танай _____-ны № _____-т

ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААН
ХАНГАМЖИЙН ГАЗАР
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.МӨНХ-АМАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Даланзадгадын дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Даланзадгадын дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Даланзадгадын дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ-ын данс бүртгэлд тусгасан 8,674.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Даланзадгадын дулаан цахилгааны станц ТӨХК ашиглаж байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 21 төсөвт байгууллага, 72 аж ахуйн нэгж 1521 айл өрхийг дулаанаар хангасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

016020340

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	699.9	405.6
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,370.6	17,004.4
Нийт хөрөнгийн дүн	17,070.5	17,410.0
Нийт өр төлбөрийн дүн	19,270.9	18,465.1
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	(2,200.4)	(1,055.1)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	17,070.5	17,410.0
Орлогын дэлгэрэнгүй тайлан		
Борлуулалтын орлогын дүн	2,898.0	2,838.0
Үйл ажиллагааны зардал болон ББӨ-н дүн	2,938.9	2,937.6
Татварын өмнөх ашиг	(40.9)	(99.6)
Татварын дүн	-	
Татварын дараах ашиг	(40.9)	(99.6)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Өмч	2,159.5	1,154.7
Хуримтлагдсан ашиг	(40.9)	(99.6)
Эцсийн үлдэгдэл	2,118.6	1,055.1
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,832.8	2,544.9
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,978.9	2,254.8
Үйл ажиллагааны ЦМГ	(146.1)	290.1
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(36.6)	(67.6)
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(182.7)	222.5
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	200.7	18.1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18.1	240.6
Зорилтот түвшин	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт борлуулалтын орлого	2,038.2	2,112.0
Үйл ажиллагааны зардал	2,026.2	2,273.3
Үйл ажиллагааны бус зардал	-	-
Нийт зардал	2,026.2	2,273.3
Татвар төлөхийн өмнөх ашиг	12.0	(161.3)
Татвар	1.2	-
Татварын дараах ашиг	10.8	(161.3)

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,488.4 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,488.4 сая төгрөгийн 1 алдааг залрууллаа.

Үүнд: Засгийн газрын 2018 оны 193 тоот тушаалыг зөрчин дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэний бууралтыг тайлант хугацааны зардалд бүртгээгүй байна.

Аудитаар нийт 18.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1 албан шаардлага 18.5 сая төгрөгийн 3 заалт бүхий зөвлөмж өгөгдлөө.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй

3.2 Албан шаардлага

5.2.1 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 159 мэдээлэл мэдээлэхээс 153 мэдээллийг хуулийн хүрээнд хугацаанд нь бүрэн байршуулсан, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн 2022 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хугацаа болоогүй байгаа тул мэдээлээгүй, өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж хуульд заасан мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлж хэрэгжилтийг нь ханган ажиллах.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь тайлант оны 11 сард борлуулалтын шинэ программ хангамж нэвтрүүлэн үйл ажиллагаандаа ашигласан байна. Тус программ хангамж нь и баримт цахим мэдээллийн системд эцсийн хэрэглэгчийг давхардуулан оруулж орлогыг 18.5 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-д “бүх орлого”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал тусгана” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллаж борлуулалтын программ хангамжид холбогдох сайжруулалтыг хийн орлогыг үнэн зөв илэрхийлж нийт орлогыг татварын и баримт цахим мэдээллийн системд үнэн зөв оруулж байх

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Тайлант хугацаанд тус байгууллага нь 386.6 сая төгрөгийн сантехникийн урсгал засварын материал худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зарлаагүй шууд гэрээ байгуулан ажиллажээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлөөлөн удирдах зөвлөлөөр техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулахдаа их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллах

3. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Тус байгууллагын эзэмшилд байгаа 8,764.0 сая төгрөгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийг Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК ашиглаж байна. Тус хөрөнгийн элэгдлийн зардал нь байгууллагын алдагдлыг нэмэгдүүлж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д “өөрт олгогдсон үл хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах”, 27 дугаар зүйлийн 27.1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн байгууллагад түншлэлийн болон түрээсийн гэрээгээр мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж ашиглуулж болно” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж тухайн хөрөнгийн эзэмшлийг тогтоон эх үүсвэр болон шугам сүлжээгээр нь салган ангилж ашиглаж байгаа газарт нь хүлээлгэн өгөх шийдвэрийг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Дахин үнэлгээний нэмэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн.	1	1,488,465.4			1	1,488,465.4	1	1,488,465.4				
Дүн	1	1,488,465.4			1	1,488,465.4	1	1,488,465.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлогыг буруу илэрхийлсэн	1	18,502.3					1	18,502.3				

Шууд гэрээгээр худалдан авалт хийсэн	1					1					
Үндсэн хөрөнгийн бүртгэл	1					1					
Дүн	3	18,502.3				3	18,502.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй	1				1					
Дүн	1				1					
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн	1				1					

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
6	ТӨОНААТҮГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			